ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
**АРВАЙХЭЭР СУМЫН**
**ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН**
**ТОГТООЛ**

2018 оны 04 сарын 11 өдөр Дугаар 6/04 Арвайхээр

Арвайхээр сумын 2018 оны төсөвт
өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-н "Б" заалт, Төсвийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.3 дахь заалтыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 4 дүгээр хуралдаанаас ТОГТООХ нь:

"Арвайхээр сумын 2018 оны төсөв батлах тухай" сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 5/08 дугаар тогтоолд дараах өөрчлөлт оруулсугай.

1. Тогтоолын 3 дугаар заалтын төсвийн ерөнхийлөн захирагч, тэдгээрийн харьяа байгууллагын төсөв зарцуулах эрхийг 98731.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэх, үүнээс 3.1-д заасан иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын урсгал зардлыг 14293.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлэх, үүнээс үндсэн үйл ажиллагааны зардлыг 15061.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн урсгал шилжүүлгийг 768.0 мянган төгрөгөөр бууруулах, 3.2-д заасан сумын Засаг даргын урсгал зардлыг 84437.8 мянган төгрөгөөр нэмэгдүүлэх, үүнээс 3.2.2-д заасан Засаг Даргын Тамгын Газрын урсгал зардлыг 96135.3 мянган төгрөгөөр нэмэгдүүлэх, үүнээс үндсэн үйл ажиллагааны зардлыг 85724.5 мянган төгрөгөөр, орон нутгийн нөөц хөрөнгийн зардлыг 48500.8 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн урсгал шилжүүлгийг 2090.0 мянган төгрөгөөр, ТҮК ОНӨААТҮГазарт олгох татаасыг 36000.0 мянган төгрөгөөр бууруулах, 3.2.3-д заасан багийн Засаг даргын албаны урсгал зардлыг 11097.5 мянган төгрөгөөр бууруулах, үүнээс үндсэн үйл ажиллагааны зардлыг 7197.5 мянган төгрөгөөр, урсгал шилжүүлгийг 3900.0 мянган төгрөгөөр бууруулах, 3.2.4-д заасан Хотын захирагчийн албаны урсгал зардлыг 600.0 мянган төгрөгөөр бууруулах, үүнээс урсгал шилжүүлгийг 600.0 мянган төгрөгөөр бууруулах.

2. Мал эмнэлгийн урсгал зардал 1942.0 мянган төгрөгийг хасах

3. Тогтоолын 4 дүгээр заалтын төсвийн жилд зарцуулах зарлагын хэмжээг 1453115.5 мянган төгрөгөөр өөрчлөн баталсугай.

4. Сумын 2018 оны төсвийн санхүүжүүлэх эх үүсвэрийг дор дурдсанаар өөрчлөн баталсугай.

4.1 Сумын татварын болон татварын бус орлого 1134312.6 мянган төгрөг, төсөвт байгууллагын өөрийн орлого 89600.0 мянган төгрөг

4.2 Сумын төсөвт аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг 154386.3 мянган төгрөг

4.3 Сумын төсөвт аймгийн төсвөөс шилжүүлэх тусгай зориулалтын шилжүүлэг 10300329.6 мянган төгрөг

4.4 Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас сумын орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг 205504.9 мянган төгрөг

4.5 Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас олгох Хот тохижуулах газрын санхүүжилт 65085.6 мянган төгрөг

4.6 Урьд оны үлдэгдлээс санхүүжих 98731.0 мянган төгрөг

4.7 Орон нутгийн хөгжлийн сангийн оны эхний үлдэгдлээс санхүүжих 2400.0 мянган төгрөг

5. Сумын төсвөөс 2018 оны төсвийн жилд зарцуулах зарлагыг зориулалт, арга хэмжээ, эдийн засгийн ангиллаар нэгдүгээр хавсралтаар өөрчлөн батлсугай.

6. Орон нутгийн хөгжлийн сангаар 2018 оны төсвийн жилд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтад орох өөрчлөлтийг хоёрдугаар хавсралтаар батлсугай.

7. Сумын төсөвт орсон өөрчлөлтийн дагуу төсвийн сар, улирлын хуваарьт өөрчлөлт оруулан хэрэгжүүлэхийг сумын Засаг дарга /О.Пүрэвдорж/-д даалгасугай.

ДАРГА Д.АМАРТҮВШИН

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 04 дугаар сарын 11-ний өдрийн 01/04 дүгаар тогтоолын нэгдүгээр хавсралт

## АРВАЙХЭЭР СУМЫН ОНБАЙГУУЛЛАГУУДЫН 2018 ОНЫ ТӨСВИЙН ТОДОТГОСОН НЭГТГЭЛ

/ Хөтөлбөр, зориулалт, Эдийн засгийн ангиллаар/

| Код | Үзүүлэлт | Сумын ИТХ | Сумын ЗДТГ | Багийн Засаг Дарга | Хот тохижилт | Сумын дүн |
|---|---|---|---|---|---|---|
| 80101 | Үндсэн үйл ажиллагааны зардал | 98222.484 | 383559.432 | 331355.732 | 36361.088 | 755910.5 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 98222.484 | 383559.432 | 331355.732 | 36361.088 | 755910.5 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 63570.7 | 212471.1 | 272278.6 | 31727.4 | 580047.8 |
| 210101 | Үндсэн цалин | 41434.2 | 175364.6 | 243003 | 31727.4 | 491529.2 |
| 210104 | Урамшуулал | 22136.5 | 1570 | | | 23706.5 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | | 35536.5 | 29275.6 | | 64812.1 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 7628.484 | 25496.532 | 32673.432 | 3807.288 | 70334.4 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 0 | 39649.6 | 17472.6 | 0 | 57122.2 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | | 5380 | 1596 | | 6976 |
| 210302 | Түлш, халаалт | | 31811.8 | 15036.6 | | 46848.4 |
| 210303 | Цэвэр, бохир ус | | 2457.8 | 840 | | 3297.8 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 3523.6 | 18113.5 | 7387.3 | 826.4 | 29850.8 |
| 210401 | Бичиг хэрэг | 1180.8 | 5108 | 1794.5 | 484.4 | 8567.7 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1748.8 | 4539.7 | 2620.8 | | 8909.3 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 594 | 6595.8 | 2412 | 342 | 9943.8 |
| 210404 | Ном хэвлэл | | 270 | | | |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | | 1600 | 560 | | 2160 |
| 2105 | Нормативт зардал | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 0 | 0 | | | 0 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 5911.2 | 61948 | 0 | 0 | 67859.2 |
| 210601 | Багаж, техник хэрэгсэл | 4061.2 | 46480 | | | 50541.2 |
| 210602 | Тавилга | 1100 | 8010 | | | 9110 |
| 210604 | Урсгал засвар | 750 | 7458 | | | 8208 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 1000 | 1890 | 0 | 0 | 2890 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1000 | 1890 | | | 2890 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж | 188.5 | 7490.7 | 1543.8 | 0 | 9223 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 46 | 6953.7 | 1543.8 | | 8543.5 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 54.5 | 54.5 | | | 109 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 55 | 145 | | | 200 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 33 | 99 | | | 132 |
| 210807 | Газрын төлбөр | | 238.5 | | | 238.5 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 16400 | 16500 | 0 | 0 | 32900 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 12300 | 16500 | | | 28800 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 4100 | | | | 4100 |
| 80404 | Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас | | 57024.6 | | | 57024.6 |
| 2122 | Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас | | 57024.6 | | | 57024.6 |
| 212201 | Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас | | 57024.6 | | | 57024.6 |
| 80802 | Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг | 132 | 3010 | 0 | 0 | 3142 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 132 | 3010 | 0 | 0 | 3142 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 132 | 3010 | | | 3142 |
| 81102 | Орон нутгийн нөөц хөрөнгө | | 68500.8 | | | 68500.8 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 68500.8 | | | 68500.8 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 68500.8 | | | 68500.8 |
| 82207 | Хотын доторхи ногоон байгууламж | | | | 474949.4 | 474949.4 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн АҮ-ний төлбөр хураамж | | | | 474949.4 | 474949.4 |
| | Нийт зардлын дүн | 98354.484 | 512094.832 | 331355.732 | 511310.488 | 1453115.5 |
| 3 | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 98354.5 | 512094.8 | 331355.7 | 511310.5 | 1453115.5 |
| 32 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 98354.5 | 511494.8 | 331355.7 | 511310.5 | 1452515.5 |
| 320001 | Орон нутгийн төсвөөс | 92722.5 | 418395.8 | 331355.7 | 446224.9 | 1288698.9 |
| 350002 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 5632 | 93099 | | | 98731 |
| 320002 | ОНХСангаас | | | | 65085.6 | 65085.6 |
| 35 | Үйл ажиллагааны орлогоос | | 600 | | | 600 |
| 62 | АЖИЛЛАГСАДЫН ТОО | 4 | 26 | 42 | 4 | 76 |
| 620001 | Удирдах ажилтан | 1 | 3 | 13 | 0 | 17 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 2 | 14 | 24 | 4 | 44 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 1 | 3 | | 0 | 4 |
| 620004 | Гэрээт ажилтан | | 6 | 5 | 0 | 11 |

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2018 оны 02 сарын 11-ний өдрийн 6/04 дугаар
тогтоолын хоёрдугаар хавсралт

## АРВАЙХЭЭР СУМЫН ОНХСАНГИЙН ХӨРӨНГӨӨР 2018 ОНД НЭМЖ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ

| № | Санхүүжүүлэх чиг үүрэг | № | Хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний нэр | 2018 онд санхүүжүүлэх |
|---|---|---|---|---|
| 1 | Төсвийн тухай хуулийн 58.4.8 Сумын тохижилт, мод ургамал,цэцэрлэгжүүлэлт, явган зам, амралт болон хүүхдийн тоглоомын талбайг тохижуулах арчлах | 1 | 12,13 дугаар багийн хаягжуулалт | 9000.0 |
| | ОНХСангийн 7.4.6 ж заалт: Айл өрх, гудамж талбайн хаягжуулалт | | | |
| 2 | Төсвийн тухай хуулийн 58.4.6 Сумын нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах | 2 | Дайргын голын толгойн боолтын засвар | 1000.0 |
| | ОНХСАнгийн зааврын 7.4.4 б заалт: Үер усны далан барих | | | |
| 3 | ОНХСангийн зааврын 7.4.6 ж заалт: Айл өрх, гудамж талбайн хаягжуулалт хийх | 3 | Төв захын баруун талын ногоон байгууламжийн хайс, хашлагыг шинэчлэх | 2400.0 |
| | ОНХСангийн зааврын 7.4.6 е заалт: Ногоон байгууламж байгуулах, мод бут, сөөг тарих, хамгаалах | | | |
| | Дүн | | | 12400.0 |

## АРВАЙХЭЭР СУМЫН ОНХСАНГИЙН ХӨРӨНГӨӨР 2018 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНЭЭС ХАСАГДАХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ

| № | Санхүүжүүлэх чиг үрэг | № | Хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний нэр | 2018 онд санхүүжүүлэх |
|---|---|---|---|---|
| 1 | Орон нутгийн төсөл боловсруулах журмын 6.3.3 | 1 | Төрийн үйлчилгээний нэгдсэн төсвийн зураг төсөл | 10,000.00 |